



МОНГОЛ УЛС  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Журам, хөтөлбөр батлах тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 7 дугаар зүйлийн 7.1.1, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 13 дугаар зарлигаар батлагдсан “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ын 2.11-д заасныг тус тус үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.“Шүүгч бэлтгэх сургалтын журам”-ыг нэгдүгээр, “Шүүгч бэлтгэх сургалтын хөтөлбөр”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журам, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал /Ц.Мандах/, зохион байгуулалтын болон хөрөнгийн эх үүсвэрийг шүүхийн төсөв, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан жил бүр төлөвлөх, журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Т.Мэндсайхан/-д тус тус үүрэг болгосугай.

3.Тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Н.ЛҮНДЭНДОРЖ

000147

## ШҮҮГЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Анхан шатны шүүхийн шүүгчийн шалгалтад тэнцсэн нэр дэвшигчийн /цаашид "сургалтад оролцогч" гэх/ шүүгч бэлтгэх сургалтыг /цаашид "сургалт" гэх/ зохион байгуулах, багц цаг тооцох, арга ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хуулиуд болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид энэ журам нийцсэн байна.

1.3. Сургалт шүүгчид тавих мэдлэг, чадварын шаардлагад нийцсэн, үр нөлөөтэй, бүтээмжтэй байх зарчимд тулгуурлана.

1.4. Сургалтыг оролцогч төвтэй, бие даан суралцах, дүрд тоглох арга зүй давамгайлсан, хэлэлцүүлэг, шүүмжлэлт дүн шинжилгээнд түшиглэсэн хэлбэрээр зохион байгуулна.

1.5. Сургалтыг хөтөлбөрийн дагуу Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн /цаашид "Хүрээлэн" гэх/ зохион байгуулна. Хүрээлэн уг сургалтыг Монголын Хуульчдын холбоо, Монголын Шүүгчдийн холбоо, Монголын шүүгч эмэгтэйчүүдийн холбоо зэрэг байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

1.6. Сургалт нь танхимын, шүүх дэх дадлага, бие даан суралцах гэсэн төрөлтэй байна.

1.7. Сургалтын зарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудсанд байршуулна

1.8. Сургалтын зардлын зарим хэсгийг сургалтад оролцогч хариуцна.

1.9. Сургалтын 1 багц цагийн төлбөр Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цагийн төлбөрийн 50 хувьтай тэнцүү байна.

1.10. Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Шүүгчийг сонгон шалгаруулах журмын 7.4-т заасан дүгнэлтийг гаргахдаа сургалтад хамрагдсан байдлыг харгалзана.

### Хоёр. Танхимын сургалт

2.1. Танхимын сургалт нь лекц, семинарын хичээлээс бүрдэнэ.

2.2. Лекцийн хичээлээр шүүхийн эрх зүйн болон шүүгчийн тогтмол хэрэглэдэг эрх зүйн эх сурвалжийн үндсэн хэм хэмжээ, зарчмуудыг бататгана.

2.3. Семинар нь дүрд тоглох /шүүх хуралдааныг удирдах, шүүх бүрэлдэхүүнд оролцох г.м./, тохиолдол шинжлэх, шүүх хуралдааны бичлэгт дүн шинжилгээ хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг хэлбэртэй байна.

### Гурав. Шүүх дэх дадлага

3.1. Шүүх дэх дадлагын явцад шүүх хуралдаанд бэлтгэх, шүүх хуралдааныг удирдах, шүүхийн хэлэлцүүлэг хийх, нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шийдвэр гаргах, бичих, танилцуулах, гардуулах зэрэг шүүгчийн гүйцэтгэдэг чиг үүрэгтэй биечлэн танилцаж, дүн шинжилгээ хийнэ. Мөн шүүхээс гарах эрх зүйн актуудыг боловсруулахад суралцана.

3.2. Шүүхэд хийсэн дадлагын үр дүнг баталгаажуулах, эргэцүүлэх зорилгоор тайлан бичиж, хамгаалуулна.

3.3. Сургалтад оролцогч шүүх дэх дадлагын тайланг сургалт зохион байгуулагчаас тогтоосон хугацаанд хураалгана.

3.4.Сургалтад оролцогчийг шүүгчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшсэн чиглэлээр шүүхүүдэд хуваарилна.

3.5.Шүүх дэх дадлага тусгайлан тохижуулсан анги, танхим болон нийслэл дэх анхан шатны шүүхэд зохион байгуулна.

3.6.Шүүх дэх дадлагыг зохион байгуулахад шүүхийн тамгын газар сургалт хийх нөхцөл, боломжийг бүрдүүлэх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.6.1.Сургалтын удирдагчийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчтэй урьдчилан зөвшилцөж томилох;

3.6.2.Шүүх дэх дадлагыг хөтөлбөр, журмын дагуу, үр бүтээлтэй зохион байгуулах, хяналт тавих;

3.6.3.Шүүх дэх дадлагын явцад сургалтад оролцогч, дадлага удирдагчийн ажлын уялдаа холбоог хангах;

3.6.4.Шүүх дэх дадлагатай холбоотой гарсан асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Хүрээлэнд мэдэгдэж шийдвэрлүүлэх.

#### **Дөрөв.Бие даалт**

4.1.Сургалтад оролцогчдод бие даан гүйцэтгэх даалгаврыг танхимын болон шүүх дэх дадлага удирдсан багш өгч, дүгнэнэ.

4.2.Бие даалтын ажилд дараах зүйлүүд байна. Үүнд:

4.2.1.Шүүгчийн ёс зүйн хорооны 3-аас доошгүй шийдвэрт дүн шинжилгээ хийх;

4.2.2.Шүүгчийн хараат бус байдал ба хариуцлага сэдвээр эссэ бичих эсхүл тухайн сэдвээр бичсэн өгүүлэлд шүүмжлэл бичих;

4.2.3.Шүүгчийн ажил хэргийн зохион байгуулалттай холбоотой эрх зүйн актуудыг судалж, асуултад хариулах;

4.2.4.Шүүх хуралдаанд сууж, шүүх хуралдааныг зохистой удирдах арга барилын талаар дүгнэлт, санал бичих;

4.2.5.3-аас доошгүй шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ бичих;

4.2.6.Эрх зүйн хэм хэмжээнд онолын тайлбар бичих;

4.2.7.Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж, асуудал дэвшүүлсэн эссэ бичих;

4.2.8.Нотлох баримт, түүнийг үнэлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж, асуудал дэвшүүлсэн эссэ бичих;

4.2.9.Хэргийн хөдөлгөөний удирдлагатай холбоотой эрх зүйн актуудыг судалж, асуултад хариулах.

#### **Тав. Сургагч багш, дадлага удирдагчид тавих шаардлага**

5.1.Сургалтыг хууль зүй, шүүн таслах ажлын өндөр мэргэшилтэй эрдэмтэн, судлаач, шүүгч-багш нар удирдана.

5.2.Сургагч багш нь оролцооны идэвхтэй аргуудыг ашиглан сургалт явуулах, гарын авлага, тараах материалыг товч, тодорхой боловсруулах, сургалтын үнэлгээ хийх, сургалтад оролцогчдын мэдлэг, ур чадварын өөрчлөлтийг бодитой үнэлэх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна.

5.3.Шүүх дэх дадлагын удирдагч нь Ерөнхий шүүгч эсхүл 5-аас доошгүй жил ажилласан шүүгч байна.

#### **Зургаа.Сургалтын багц цагийг тооцох, үнэлэх**

6.1.Сургалт нийт 24 багц цаг байна. Сургалтын 8 цагийг нэг багц цагт тооцно. Нэг цагийн сургалтын үргэлжлэх хугацаа 45 минут байна.

6.2.Сургалтын багц цагийг танхимын сургалт болон шүүх дэх дадлагад хангалттай үнэлгээ авсан тохиолдолд тооцно.

6.3.Маягт №1-т заасан 4 шалгуурын дагуу танхимын сургалтын сэдэв тус бүрийг үнэлнэ. Маягт №1-т заасан 2 ба түүнээс дээш шалгуурт “Хангалттай” үнэлгээ авсан тохиолдолд тухайн сэдвийг “Хангалттай” судалсан гэж тооцно.

6.4.Танхимын сургалтын нийт сэдвийн 60 ба түүнээс дээш хувийн сэдвийг “Хангалттай” гэж тооцуулсан тохиолдолд танхимын сургалтыг “Хангалттай” гэж үнэлнэ.

6.5.Шүүх дэх дадлагын тайлангийн хамгаалалтад дадлага удирдагч, сургалт зохион байгуулагч байгууллагын төлөөлөл байна.

6.6.Маягт №2-т заасан 2 ба түүнээс дээш шалгуурт “Хангалттай” үнэлгээ авсан тохиолдолд шүүх дэх дадлагыг “Хангалттай” гэж үнэлнэ.

6.7.Хүрээлэн сургалтад оролцогчийн үнэлгээг Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулна.

~oOo~

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны  
06 сарын 11-ны өдрийн 29 дугаар тогтоолын  
нэгдүгээр хавсралтын маягт №1



### СУРГАЛТАД ОРОЛЦОГЧИЙН ТАНХИМЫН СУРГАЛТЫГ ҮНЭЛЭХ ХУУДАС

Сургалтад оролцогчийн овог, нэр:<sup>1</sup>.....

Сургалтын сэдэв: .....

№	Шалгуур	Үнэлгээ	Тайлбар УХА0052 1701517
1	Лекцийн ирц, идэвх, оролцоо		
2	Семинарын ирц, идэвх, оролцоо		
3	Бие даалт	Шүүгчийн ёс зүйн хорооны 3-аас доошгүй шийдвэрт дүн шинжилгээ	
		Шүүгчийн хараат бус байдал ба хариуцлага сэдвээр эссэ бичих эсхүл тухайн сэдвээр бичсэн өгүүлэлд шүүмжлэл	
		Шүүгчийн ажил хэргийн зохион байгуулалттай холбоотой эрх зүйн актуудыг судалж, асуултад хариулсан байдал	
		Шүүх хуралдаанд сууж, шүүх хуралдааныг зохистой удирдах арга барилын талаар бичсэн дүгнэлт, санал	
		Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ /3-аас доошгүй /	
		Эрх зүйн хэм хэмжээнд онолын тайлбар бичих	
		Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж бичсэн, асуудал дэвшүүлсэн эссэ	
		Нотлох баримт, түүнийг үнэлэхтэй холбоотой эрх зүйн эх сурвалжуудыг судалж бичсэн, асуудал дэвшүүлсэн эссэ	
	Хэргийн хөдөлгөөний удирдлагатай холбоотой эрх зүйн актуудыг судалж, асуултад хариулсан байдал		
4	Шүүх хуралдааныг удирдах, оролцох зэрэг дүрд тоглосон байдал		

Жич: Сургалтад оролцогчийг үнэлэхдээ "Хангалттай"/"Хангалтгүй" гэж үнэлнэ. Суралцагчийг "Хангалттай"/"Хангалтгүй" гэж үнэлэх болсон шалтгаанаа тайлбарлан бичнэ.

#### Лекц уншсан сургагч багш:

.....  
(Албан тушаал)  
..... /  
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)  
.....  
(Огноо)

#### Семинар удирдсан сургагч багш:

.....  
(Албан тушаал)  
..... /  
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)  
.....  
(Огноо)

<sup>1</sup> Суралцагчийн овог, нэрийг товчлохгүй бүтнээр бичнэ. Жишээ: Бат овогтой Болд

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны  
06 сарын 11-ны өдрийн 29 дугаар тогтоолын  
нэгдүгээр хавсралтын маягт №2



## СУРГАЛТАД ОРОЛЦОГЧИЙН ШҮҮХ ДЭХ ДАДЛАГЫГ ҮНЭЛЭХ ХУУДАС

Дадлагад гарсан шүүхийн нэр:<sup>2</sup>.....

Сургалтад оролцогчийн овог, нэр:<sup>3</sup>.....

№	Шалгуур	Үнэлгээ	Тайлбар
1	Оролцоо /ирц, идэвх/		
2	Шүүх хуралдааныг удирдах, оролцох зэрэг дүрд тоглосон байдал		
3	Тайлан		

Жич: Суралцагчийг үнэлэхдээ "Хангалттай"/"Хангалтгүй" гэж үнэлнэ. Суралцагчийг "Хангалттай"/"Хангалтгүй" гэж үнэлэх болсон шалтгаанаа тайлбарлан бичнэ.

### Дадлага удирдагч:

.....  
(Албан тушаал)  
..... /...../  
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)  
.....  
(Огноо)

### Сургалт зохион байгуулагч байгууллагын төлөөлөл:

.....  
(Албан тушаал)  
..... /...../  
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)  
.....  
(Огноо)

<sup>2</sup> Дадлагад гарсан шүүхийн нэрийг товчлохгүй бүтнээр бичнэ. Жишээ: Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх

<sup>3</sup> Суралцагчийн овог, нэрийг товчлохгүй бүтнээр бичнэ. Жишээ: Бат овогтой Болд

## ШҮҮГЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

УХА0052 1701517



### СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА:

<b>Сургалтын нэр:</b>	Шүүгч бэлтгэх сургалт
<b>Сургалтын код:</b>	JU01
<b>Нийт цаг:</b>	192
<b>Багц цаг:</b>	24 кредит
<b>Ангилал:</b>	Заавал судлах

### Нэг.Зорилго, зорилт

#### 1.1.Хөтөлбөрийн зорилго

Анхан шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшиж, шалгалтад тэнцсэн нэр дэвшигчид шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай суурь мэдлэг болон материаллаг, процессын эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, шүүгчийн мэргэжлийн онцлог, ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд туслалцаа үзүүлэх, шүүгчээр томилогдохоос өмнө урьдчилан дадлагажуулахад хөтөлбөрийн зорилго оршино.

#### 1.2.Хөтөлбөрийн зорилт

- Шүүн таслах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх;
- Шүүгчийн мэргэжлийн онцлог, шүүгчийн ёс зүй, харилцаа хандлагын талаарх мэдлэг олгож, хандлагыг төлөвшүүлэх;
- Салбар эрх зүйн хүрээнд хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүйн мэдлэг, шүүхийн шийдвэр боловсруулах арга зүйн мэдлэг, чадварыг олгох;
- Шүүгчээр томилогдохоос нь өмнө шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх чадварт суралцуулж, дадлагажуулж, бэлтгэх.

### Хоёр.Сургалтын сэдэв, цагийн хуваарилалт

№	Сургалтын сэдэв	Агуулга	Кредит цаг	Цагийн хуваарилалт				
				Танхимын сургалт		Шүүх дэх дадлага	Бие даалт	
				Лекц	Семинар			
1	Шүүхийн эрх зүй	1. Үндсэн хууль дахь шүүх эрх мэдлийн суурь зарчмууд; 2. Шүүхийн тогтолцоо загвар, үндсэн асуудал; 3. Шүүх эрх мэдэл ба шүүгч; 4. Шүүх эрх мэдлийн бие даасан байдал, түүний шалгуур; 5. Шүүхийн захиргаа, загвар, онцлог чиг үүрэг, хэмжээ хязгаар.	1	0.5 (4 ц)	0.5 (4 ц)	-	-	
2	Шүүгчийн ёс зүй	1. Шүүгчийн ёс зүйн зарчмууд; 2. Шүүгчийн ёс зүйн дүрэм (кодекс) ; 3. Шүүгчийн болон хуульчийн баримтлах нийтлэг зарчим, агуулга.	2	1 (8 ц)	0.5 (4 ц)	-	0.5 (4 ц)	
3	Шүүгчийн хараат бус байдал ба хариуцлага	1. Шүүгчийн хараат бус байдлын тухай ойлголт, түүний Үндсэн хуулийн эрх зүйн үндэс; 2. Шүүгчийн хараат бус байдлын бүрдэл хэсэг: албаны болон хувийн хараат бус байдал; 3. Шүүгчийн болон хуульчийн баримтлах нийтлэг үүрэг, агуулга.	2	1 (8 ц)	0.5 (4 ц)	-	0.5 (4 ц)	
4	Шүүхийн сэтгэл зүй, шүүгчийн харилцаа хандлага	1. Хуульч мэргэжлийн сэтгэл зүйн онцлог; 2. Стресс, түүнийг даван туулах нь; 3. Түгээмэл тохиолддог сэтгэл зүйн өвчин, тэдгээрийн онцлог; 4. Хэргийн оролцогчийн сэтгэл зүй; 5. Шүүгчийн зан төлөв (judicial temperament) ; 6. Шүүгчийн нийгмийн (социаль) дүр төрх ба харилцаа, хандлага: шүүхэд итгэх олон нийтийн итгэл 7. Шүүгчийн харилцааны онцлог; 8. Шүүгч хэргийн оролцогчидтой үр нөлөөтэй харилцах нь.	2	1 (8 ц)	1 (8 ц)	-	-	
5	Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй	Эрүү Иргэн Захиргаа	1. Хууль тайлбарлах ба хэрэглэх ойлголтын агуулга; 2. Хууль тогтоогчийн хүсэл ба хуулийг тайлбарлан хэрэглэх; 3. Эрх зүйт хэм хэмжээг тайлбарлах зарчим, үнэт зүйлс, үзэл санаа: Эрх зүйт ёс (rule of law), эрх зүйн зайлшгүй процесс (due process), нийгмийн зөвшилцөл; 4. Хууль тайлбарлах онолын чиг хандлага; 5. Салбар эрх зүйн зарчмууд; 6. Салбар эрх зүй дэх хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй.	2	1 (8 ц)	1 (8 ц)	-	-
6	Нотлох баримт, түүнийг үнэлэх	Эрүү Иргэн Захиргаа	1. Хэрэг, маргааны үйл баримтыг тогтоох; 2. Хэрэг, маргааны хүрээнд хууль зүйн дүгнэлт хийх; 3. Үйл баримтыг тогтоох болон хууль зүйн дүгнэлт хийхэд шүүгчийн үзэмж, хуульчийн санал дүгнэлтийг харгалзах; 4. Нотлох баримт, онцлог, түүнийг үнэлэх.	2	0.5 (4 ц)	0.5 (4 ц)	0.5 (4 ц)	0.5 (4 ц)



№	Сургалтын сэдэв	Агуулга	Кредит цаг	Цагийн хуваарилалт			
				Танхимын сургалт		Шүүх дэх дадлага	Бие даалт
				Лекц	Семинар		
7	Шүүх хуралдаанд бэлтгэх, хуралдаан удирдах	<p>Эрүү</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүх хуралдаанд бэлтгэх, урьдчилсан хэлэлцүүлэг;</li> <li>2. Анхан шатны шүүх хуралдааны дэг, дараалал;</li> <li>3. Шүүх хуралдаанд оролцогчдын эрх, үүрэг;</li> </ol> <p>Иргэн</p> <ol style="list-style-type: none"> <li>4. Шүүх хуралдаан даргалах шүүгчийн арга барил;</li> <li>5. Шүүх хуралдааны дэг сахиулах (алх хэрэглэх);</li> <li>6. Шүүхийн өмнөх, шүүхийн, шүүх хуралдааны дараах үе шатууд дахь онцлог;</li> </ol> <p>Захиргаа</p> <ol style="list-style-type: none"> <li>7. Шүүх хуралдааны үед болон шүүх хуралдааны дараа анхаарах асуудал;</li> <li>8. Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох, зөвлөлдөх;</li> <li>9. Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох, тайлбарлах.</li> </ol>	2	-	1 (8 ц)	1 (8 ц)	-
8	Мэтгэлцэх зарчим	<ol style="list-style-type: none"> <li>1. Мэтгэлцэх зарчим;</li> <li>2. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт мэтгэлцэх зарчмыг хангах;</li> <li>3. Шүүх нотлох зарчим ба мэтгэлцэх зарчмын тэнцвэр;</li> <li>4. Эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдааны үеэр мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх онцлог.</li> </ol>	1	-	0.5 (4 ц)	0.5 (4 ц)	-
9	Шүүхийн шийдвэр гаргах	<p>Эрүү</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүхээс гарах актын төрөл, бүтэц, бичих арга техник;</li> <li>2. Тодорхойлох болон үндэслэх хэсэг бичих аргачлал, субсумц хийх;</li> </ol> <p>Иргэн</p> <ol style="list-style-type: none"> <li>3. Шийдвэр боловсруулах арга, ажиллагаа;</li> <li>4. Шүүхийн шийдвэр гаргах, танилцуулах;</li> </ol> <p>Захиргаа</p> <ol style="list-style-type: none"> <li>5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлд хяналт тавих.</li> </ol>	2	0.5 (4 ц)	0.5 (4 ц)	0.5 (4 ц)	0.5 (4 ц)
10	Хялбаршуулсан журмаар болон шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх	<ol style="list-style-type: none"> <li>1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам;</li> <li>2. Эвлэрлийг баталгаажуулах;</li> <li>3. Арбитрын шийдвэрийг баталгаажуулах;</li> <li>4. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа.</li> </ol>	1	-	0.5 (4 ц)	-	0.5 (4 ц)
11	Шүүгчийн ажлын зохион байгуулалт	<ol style="list-style-type: none"> <li>1. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх;</li> <li>2. Шүүх шударга ёсны баталгаа болох нь;</li> <li>3. Шүүгчийн хууль ёсны эрх ашиг сонирхол, түүний хамгаалалт;</li> <li>4. Нөлөөллийн мэдүүлэг;</li> <li>5. Шүүгчийн ажлын зохион байгуулалт, цаг ашиглалт;</li> <li>6. Бичиг хэрэг, архив;</li> <li>7. Шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүхийн захиргааны ажилтантай харилцах</li> <li>8. Шүүгч хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах.</li> </ol>	1	-	0.5 (4 ц)	-	0.5 (4 ц)

№	Сургалтын сэдэв	Агуулга	Кредит цаг	Цагийн хуваарилалт			
				Танхимын сургалт		Шүүх дэх дадлага	Бие даалт
				Лекц	Семинар		
12	Хэргийн хөдөлгөөний удирдлага	Эрүү Иргэн Захиргаа 1. Хэргийн хөдөлгөөний удирдлага; 2. Хэргийн хугацаа хэтрэлт, Хэрэг хуваарилах журам; 3. Шүүгчийн хэргийн хөдөлгөөний манлайлал, чиг үүрэг; 4. Хэргийн хөдөлгөөний удирдлагын програм, түүний хэрэглээ.	3	-	1 (8 ц)	1.5 (12 ц)	0.5 (4 ц)
13	Шүүгчийн нийгмийн мэдрэмж	1. Шүүхийн шийдвэрийн хэргийн оролцогчдын нийгэм-сэтгэл зүй, эрх зүйн байдалд үзүүлэх нөлөө, үр дагавар; 2. Шийдвэр гаргахад нөлөөлөх субъектив хүчин зүйлүүд, урьдчилан сэргийлэх нь; 3. Цаг үеийн үзэл бодол ба нийгмийн үнэт зүйлс; 4. Шүүх эрх мэдэл ба нийгмийн харилцаа; 5. Шүүгчийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба төвийг сахих зарчим; 6. Шүүгч олон нийтийн цахим сүлжээг зохистой ашиглах, нийгмийн сүлжээнд бусадтай харилцах; 7. Хүний эрх, эрхэм чанарыг хүндэтгэх; 8. Тэгш эрх ба үл ялгаварлах зарчим.	1	0.5 (4 ц)	0.5 (4 ц)	-	-
14	Шүүхийн практик судлал	1. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ; 2. Шүүн таслах ажиллагааны статистикийн мэдээ, тайлан; 3. Шүүхийн практик судлал.	2	-	1 (8 ц)	-	1 (8 ц)
<b>Нийт</b>			<b>24</b> <b>(192 цаг)</b>	<b>6</b> <b>(48 цаг)</b>	<b>9.5</b> <b>(76 цаг)</b>	<b>4</b> <b>(32 цаг)</b>	<b>4.5</b> <b>(36 цаг)</b>